



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/753

Булган сум

**Үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2, 46 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах зардлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Зарцуулах эрх олгосон орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулж, нягтлан бодох бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга), Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зарцуулалтын эрхийг нээж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 21-ны/ний өдрийн А. /А.С. Дугаар
захирамжийн хавсралт



Үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрх

д/д	Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Ирүүлсэн санал (мянган төгрөг)	Хянасан дүн (мянган төгрөг)
1	2	3	4	5
Орон нутгийн өмчийн газар (хөтөлбөрийн код 70426)				
1	80802/213209	Нэг удаагийн тэтгэмж	2,370.0	2,370.0
1	80101/210302	Түлш халаалт	1,580.0	1,580.
Дүн			3,950.0	3,950.0
Худалдан авах ажиллагааны газар (хөтөлбөрийн код 70418)				
1	80802/213209	Нэг удаагийн тэтгэмж	1,000.0	1,000.0
2	80101/210602	Тавилга	770.0	770.0
Дүн			1,770.0	1,770.0